

ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хөвсгөл аймгийн Чандмань-Өндөр сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2024 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайлан

Аудитын код: ХӨА-2025/021/НА-СТА-ТТЗ

Цахим хуудас:
www.audit.mn

Хөвсгөл аймаг
2025 он

Дарга, тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар
Утас: 88883317 Цахим хаяг: erdenebaatara@audit.gov.mn
Аудитын менежер: Б.Тэгшдэлгэр
Утас: 99089114 Цахим хаяг: tegshdelgerb@audit.gov.mn
Ахлах аудитор: Б.Давааням
Утас: 92113932 Цахим хаяг: davaanyamb@audit.gov.mn
Ахлах аудитор: Г.Ичинхорлоо
Утас: 88012671 Цахим хаяг: ichnkhlorlooga@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	4
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	6
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	9
4. АУДИТЫН ТАЙЛАН	
4.1 Ерөнхий зүйл	18
4.2 Материаллаг байдал	18
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт.....	18
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	18
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	18
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	19
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	19
5.1 Төлбөрийн акт.....	20
5.2 Албан шаардлага	20
5.3 Зөвлөмж	20
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	21

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн Өмчийн Бодлого Зохицуулалтын Газар
ЗДТГ	Засаг Даргын Тамгын Газар
ААНОАТ	Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар



ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120
Утас/факс: 7038 3793, Цахим шуудан: khuvsgul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2025.03.25 № 1/321
танай _____-ны № _____-т

ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЧАНДМАНЬ-
ӨНДӨР СУМЫН ЗАСАГ ДАРГА ДАРГА
Д.БОЛД-ЭРДЭНЭ ТАНАА

Хараат бус аудиторын дүгнэлт

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Чандмань-Өндөр сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлогыг нийт дүнгээр нь 245.1 сая төгрөгөөр давуулан биелүүлсэн байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Аудитаар орон нутгийн орлогыг нэр төрлөөр нь биелүүлээгүй болон хоршоо хөгжүүлэх сангаас олгосон зээлийн хугацаа хэтэрсэн үлдэгдэл, шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой 28.5 сая төгрөгийн зөрчилд 3 зөвлөмж хүргүүлсэн.

Бусад асуудлын хэсэг

Чандмань-Өндөр сумын Засаг дарга нь аймгийн Засаг даргатай 2024 онд хамтран ажиллах гэрээ байгуулж 74.8 хувьтай биелүүлж ажилласан байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн төвлөрүүлэн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.



ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР *[Signature]* А.ЭРДЭНЭБААТАР

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

Код:	Тайлангийн үзүүлэлт	Тодруулга	2023оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН		400,894.60	807,330.70
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	3а, 3б	182,182.90	627,215.40
33	АВЛАГА	5а, 5б, 6а, 6б	82,942.00	22,883.80
35	БАРАА МАТЕРИАЛ	8а, 8б, 8в	135,769.70	157,231.50
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН		1,115,950.80	1,070,912.60
37	УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	11а, 11б	146,881.80	107,290.20
37300	Урт хугацаат зээл		146,881.80	107,290.20
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	12а, 12б, 12в	969,069.10	963,622.40
39200	Биет хөрөнгө		883,552.20	878,227.60
39300	Биет бус хөрөнгө	13	85,516.90	85,394.80
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II		1,516,845.40	1,878,243.30
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР		48.2	0
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	15а, 15б	48.2	0
41300	Өглөг	17а, 17б	48.2	0
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН		1,516,797.20	1,878,243.30
51	Засгийн газрын хувь оролцоо		1,516,797.20	1,878,243.30
51100	Засгийн газрын оруулсан капитал		330,172.40	330,172.40
51200	Хуримтлагдсан үр дүн		877,992.80	1,239,439.00
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү		308,632.00	308,632.00
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V		1,516,845.40	1,878,243.30

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

Код:	Тайлангийн үзүүлэлт	Тодруулга	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)		1,263,353.80	1,961,083.80
11	ТАТВАРЫН ОРЛОГО		436,717.60	800,532.80
110	Орлогын албан татвар		216,408.60	461,708.60
1100	Хувь хүний орлогын албан татвар		230,576.80	461,708.60
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт		-14,168.10	0
113	Хөрөнгийн албан татвар		34,081.10	32,691.60
118	Бусад татвар, төлбөр, хураамж		186,227.80	306,132.60
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1а, 1б	30,162.40	32,231.80
120	Нийтлэг татварын бус орлого		30,162.40	32,231.80
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		796,473.80	1,128,319.20
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2а, 2б	1,591,907.40	1,560,610.90
21	УРСГАЛ ЗАРДАЛ		1,591,907.40	1,560,610.90
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		1,515,422.30	1,463,518.80
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		486,545.60	711,145.90
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		60,664.90	88,460.20
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		24,057.30	235,750.40
2104	Хангамж, бараа материалын зардал		74,279.10	70,118.90
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		95,758.40	147,580.20
2107	Томилолт, зочны зардал		5,999.40	6,465.60
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		482,312.20	31,001.60
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		285,805.40	172,996.20
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		76,485.10	97,092.10
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)		-328,553.60	400,472.90
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН		12,116.30	38,560.90
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)		-340,669.80	361,912.00

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	1,285,935.9	2,005,509.1
11	ТАТВАРЫН ОРЛОГО	436,717.6	800,532.8
110	Орлогын албан татвар	216,408.6	461,708.6
1100	Хувь хүний орлогын албан татвар	230,576.8	461,708.6
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	-14,168.1	0.0
113	Хөрөнгийн албан татвар	34,081.1	32,691.6
118	Бусад татвар, төлбөр, хураамж	186,227.8	306,132.6
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	10,433.2	10,506.7
1181	Газрын төлбөр	31,550.9	14,423.0
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	144,243.8	281,202.9
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	52,744.5	76,657.0
120	Нийтлэг татварын бус орлого	52,744.5	76,657.0
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	796,473.8	1,128,319.2
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,481,774.4	1,292,620.6
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,481,774.4	1,292,620.6
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,168,428.8	1,198,628.5
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	486,533.1	711,157.9
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	60,728.6	88,397.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	24,549.5	237,767.9
2104	Хангамж, бараа материалын зардал	34,767.8	38,151.4
2105	Нормативт зардал	0.0	1,500.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	7,282.1	44,464.3
2107	Томилолт, зочны зардал	5,999.4	6,465.6
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	484,502.2	34,301.6
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	64,066.0	36,422.9
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	313,345.6	93,992.1
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	-195,838.5	712,888.4
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	7,500.0	267,856.0
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	7,500.0	267,856.0
2200	Дотоод эх үүсвэрээр	7,500.0	267,856.0
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-7,500.0	-267,856.0
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	-139,000.0	0.0
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	139,000.0	0.0
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	-342,338.5	445,032.4
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	524,521.4	182,182.9
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	182,182.9	627,215.4

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,857,467.0	1,857,467.0
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	2,828.0	2,828.0
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,860,295.1	1,860,295.1
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-2,828.0	-2,828.0
9	Тайлант үеийн үр дүн	-340,669.8	-340,669.8
10	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,516,797.2	1,516,797.2
11	2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	1,516,797.2	1,516,797.2
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-465.9	-465.9
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,516,331.3	1,516,331.3
19	Тайлант үеийн үр дүн	361,912.0	361,912.0
20	2024 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	1,878,243.3	1,878,243.3

2.5 Аудит хийсэн нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,846,121.7	1,497,214.9	348,906.8	81.1
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,433,800.3	1,271,644.9	162,155.4	88.7
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,389,865.9	1,228,065.4	161,800.5	88.4
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	805,179.9	711,157.9	94,022.0	88.3
210101	Үндсэн цалин	716,310.7	449,517.7	266,793.0	62.8
210102	Нэмэгдэл	80,869.2	219,695.6	(138,826.4)	271.7
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	7,405.0	(7,405.0)	
210104	Урамшуулал	8,000.0	34,539.6	(26,539.6)	431.7
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	100,647.4	88,397.0	12,250.4	87.8
210201	Тэтгэврийн даатгал	67,819.7	60,191.2	7,628.5	88.8
210202	Тэтгэмжийн даатгал	8,745.3	7,267.5	1,477.8	83.1
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,383.0	4,084.9	2,298.1	64.0
210204	Ажилгүйдлийн даатгал	1,595.8	3,153.5	(1,557.7)	197.6
210205	Эрүүл мэндийн даатгал	16,103.6	13,700.0	2,403.6	85.1
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	231,908.0	227,811.2	4,096.8	98.2
210301	Гэрэл, цахилгаан	48,968.0	50,001.4	(1,033.4)	102.1
210302	Түлш, халаалт	173,440.0	176,162.3	(2,722.3)	101.6
210303	Цэвэр, бохир ус	9,500.0	1,647.4	7,852.6	17.3
2104	Хангамж, бараа материалын зардал	40,042.0	37,151.4	2,890.6	92.8
210401	Бичиг хэрэг	3,300.0	2,840.8	459.2	86.1
210402	Тээвэр, шатахуун	26,500.0	26,407.1	92.9	99.6
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,940.0	2,640.0	300.0	89.8
210404	Ном, хэвлэл	350.0	-	350.0	-
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	5,202.0	3,557.0	1,645.0	68.4
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,750.0	1,706.5	43.5	97.5
2105	Нормативт зардал	1,500.0	1,500.0	-	100.0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,500.0	1,500.0	-	100.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	61,609.1	60,550.3	1,058.8	98.3
210601	Багаж, техник, хэрэгсэл	8,866.8	8,000.0	866.8	90.2
210602	Тавилга	2,000.0	2,000.0	-	100.0
210604	Урсгал засвар	50,742.3	50,550.3	192.0	99.6
2107	Томилолт, зочны зардал	6,500.0	6,465.6	34.4	99.5
210702	Дотоод албан томилолт	6,500.0	6,465.6	34.4	99.5
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	107,365.5	60,501.6	46,863.9	56.4
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	101,930.5	55,667.8	46,262.7	54.6
210803	Даатгалын үйлчилгээ	500.0	114.5	385.6	22.9
210804	Тээврийн хэрэгслийн татвар	500.0	379.3	120.7	75.9
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	55.0	55.0	-	100.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	2,380.0	2,285.0	95.0	96.0
210807	Газрын төлбөр	2,000.0	2,000.0	-	100.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	35,114.0	34,530.5	583.6	98.3
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	29,900.0	29,472.3	427.8	98.6
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	5,214.0	5,058.2	155.8	97.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	43,934.4	43,579.5	354.9	99.2
2132	Бусад урсгал шилжүүлэг	43,934.4	43,579.5	354.9	99.2

Хөвсгөл аймгийн Чандмань-Өндөр сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайлан

213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	32,894.8	32,754.9	139.9	99.6
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	11,039.6	10,824.6	215.0	98.1
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	347,421.4	225,570.0	121,851.4	64.9
223001	Бусад хөрөнгө	347,421.4	225,570.0	121,851.4	64.9
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	64,900.0	-	64,900.0	-
230001	Эргэж төлөгдөх зээл	64,900.0	-	64,900.0	-
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,846,121.7	1,620,937.3	225,184.4	87.8
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	257,084.9	-	257,084.9	-
310004	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих	257,084.9	-	257,084.9	-
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,367,455.5	1,548,609.8	(181,154.3)	113.2
320001	Орон нутгийн төсвөөс	1,367,455.5	1,291,524.9	75,930.6	94.4
320002	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	-	257,084.9	(257,084.9)	
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	221,581.3	72,327.5	149,253.8	32.6
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	64,000.0	63,017.7	982.3	98.5
350002	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,800.0	9,309.8	(7,509.8)	517.2
350003	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	155,781.3	-	155,781.3	-
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	67,098.9	(67,098.9)	
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	190,821.3	(190,821.3)	

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Код	Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/ ТЗ цэвэр дүн
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	63,525.1
21	УРСГАЛ ЗАРДАЛ	63,525.1
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	12,849.1
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	9,956.7
210301	Гэрэл, цахилгаан	9,956.7
2104	Хангамж, бараа материалын зардал	1,000.0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,000.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,892.5
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,892.5
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	50,676.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	50,412.6
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	50,412.6
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	263.4
213403	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, төвлөрүүлэх шилжүүлэг	263.4
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	63,525.1
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	63,525.1
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	63,140.1
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	385.0

3. САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Байгууллагын үйл ажиллагааны чиглэл, зорилго, зорилтын талаар: Чандмань-Өндөр сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч нь төсвийн ерөнхийлөн захирагчаас хуваарилсан чиг

үүргийн төсвийг төлөвлөх, төсвийн шууд захирагчид хуваарилах, хяналт тавих, хууль тогтоомжийн дагуу захиран зарцуулах, гүйцэтгэлийг тайлагнах эрх бүхий этгээд юм.

Чандмань-Өндөр сумын төсвийн төвлөрүүлэн захирагч нь тайлант хугацаанд “Хүүхдийн хөгжил хамгааллыг дэмжих жил” гэсэн эрхэм зорилго дэвшүүлэн ажилласан байна.

Тус сумын Засаг дарга нь аймгийн Засаг даргатай 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө байгуулж, хэрэгжилтийг 74.8 хувьтай биелүүлж ажилласан байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн орчны талаар: Тус төвлөрүүлэн захирагчийн харьяанд байгаа байгууллагууд нь Төсвийн тухай хууль, Засаг захиргаа нутаг дэвсгэрийн удирдлагын тухай хууль болон бусад хууль тогтоомж, журам зааврыг мөрдөн ажилласан байна.

Тус төвлөрүүлэн захирагчийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд орон нутгийн ерөнхий орлого болон 2 төсөвт байгууллага, 2 орон нутгийн сан, нийт 5 байгууллагын санхүүгийн тайлан нэгтгэгдсэн байна. Гүйцэтгэлээр санхүүжиж буй улсын төсөвт байгууллагуудад олгосон байр ашиглалттай холбоотой тогтмол зардлын санхүүжилтийг мөн нэгтгэж тайлагнасан байна.

Байгууллагын дотоод хяналтын талаар: Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор баталсан Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам"-ийн дагуу Чандмань-Өндөр сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн дэргэдэх орон тооны бус дотоод хяналтын нэгжийг Засаг даргын 2020 оны А/55 тоот тушаалаар 7 хүний бүрэлдэхүүнтэй байгуулсан байна.

Дотоод хяналтын нэгж нь 2024 онд 10 ажил хийхээр төлөвлөж, хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө батлуулан харьяа байгууллагуудын дотоод хяналтын нэгж, орон нутгийн орлого бүрдүүлэлт, Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт, худалдан авах ажиллагаа, улс орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт болон орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдсэн ажлын гүйцэтгэл, Хоршоо хөгжүүлэх сангийн зээл олголт зэрэг үйл ажиллагаанд дотоод хяналтыг хэрэгжүүлсэн байна. Дотоод хяналтаар илэрсэн зөрчлийг тухай бүр арилгаж ажилласан байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хэсгийг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзлээ.

Хөвсгөл аймгийн Санхүүгийн хяналт аудитын албанаас дотоод аудитыг хэрэгжүүлдэг ба тайлант онд Чандмань-Өндөр сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн харьяа байгууллагуудын 2021-2023 оны санхүүгийн үйл ажиллагаанд аудит хийж тайлагнасан байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Чандмань-Өндөр сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2024 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэж, Төсвийн тухай хуулийн 54.4, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан иж бүрдийн дагуу бэлтгэж толилуулсан байна гэж үзлээ.

Харин төсвийн гүйцэтгэлийн тайланг мөнгөн сууриар бэлтгэж, Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5 дахь заалтад заасан заалтын дагуу иж бүрэн ирүүлсэн.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Чандмань-Өндөр сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2024 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайланг Сангийн сайдын 2005 оны 341 дугаар тушаалаар баталсан “Санхүүгийн нэгтгэсэн тайлан гаргах зааврын”-ын дагуу бэлтгэсэн байна. Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 361.4 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөгөөр/ Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	182.2	627.2	445.0
Авлага	82.9	22.9	(60.1)
Бараа материал	135.8	157.2	21.5
Урт хугацаат зээл	146.9	107.3	(39.6)
Үндсэн хөрөнгө	969.1	963.6	(5.4)
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,516.8	1,878.2	361.4
Өглөг	0.1	0.0	(0.1)
Засгийн газрын хувь оролцоо	1,516.8	1,878.2	361.4
ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,516.8	1,878.2	361.4

Эх сурвалж: Чандмань-Өндөр сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2024 оны санхүүгийн байдлын тайлан

3.4.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл 627.2 сая төгрөг болж, өмнөх оноос 445.0 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 2. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөгөөр/ Өсөлт (+), Бууралт (-)
Төрийн сангийн харилцах	182.2	627.2	445.0
Дүн	182.2	627.2	445.0

Эх сурвалж: Чандмань-Өндөр сумын ТТЗ-ийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 445.0 сая төгрөгөөр нэмэгдэхэд орон нутгийн орлого 245.1 сая төгрөгөөр давж биелсэн, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн зарим төсөл арга хэмжээнүүд тайлант онд хэрэгжээгүй, хоршоо хөгжүүлэх сангаас тайлант онд зээл олгоогүй, өмнөх олгосон зээлээс тайлант онд 58.8 сая төгрөгийн төлөлт хийсэн зэрэг нь нөлөөлсөн байна.

Аудитын илрүүлэлт

Аудитаар мөнгөн хөрөнгийн данстай холбоотой алдаа зөрчил илрээгүй.

3.4.2 Авлага

Авлага дансны эцсийн үлдэгдэл 22.9 сая төгрөг болж, өмнөх оноос 60.1 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 3. Авлагын үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөгөөр/ Өсөлт (+), Бууралт (-)
Ажиллагчидтай холбогдсон авлага	0.1	-	(0.1)
Зээлийн хүүгийн авлага	11.7	1.7	(10.0)
Хувь хүмүүст олгосон зээл	71.2	21.2	(50.0)
Дүн	82.9	22.9	(60.1)

Эх сурвалж: Чандмань-Өндөр сумын ТТЗ-ийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Авлага дансны үлдэгдэл 60.1 сая төгрөгөөр буурсан нь хоршоо хөгжүүлэх сангаас олгосон зээлээс 58.8 сая төгрөгийн төлөлт хийсэн, 35.9 сая төгрөгийн зээлийг шүүхийн шийдвэрээр хүчингүй болгосонтой холбоотой байна.

Хоршоо хөгжүүлэн сангаас олгосон хугацаа хэтэрсэн зээлийн авлага өмнөх оноос 70.2 хувиар буурсан байна.

1. Аудитын илрүүлэлт:

Хоршоо хөгжүүлэх сангийн зээлийн үлдэгдэлд хяналт хэрэгжүүлэхэд 8 иргэний 21.2 сая төгрөгийн хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэлтэй байна. Энэ нь Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2021 оны 361 дүгээр тушаалаар баталсан "хоршоог хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журам"-ын 3.2.1."орон нутгийн жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх тэргүүлэх чиглэлийг жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ, хоршоо хөгжүүлэх бодлоготой уялдуулан тогтоож, хэрэгжилтийг зохион байгуулах, биелэлтэд нь хяналт тавих" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Зөвлөмж өгөх

3.4.3 Урьдчилгаа

Урьдчилж төлсөн зардал гараагүй байна.

3.4.4 Бараа материал

Бараа материалын дансны эцсийн үлдэгдэл 157.2 сая төгрөг болж, өмнөх оноос 21.5 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 4. Бараа материалын үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөгөөр/
			Өсөлт (+), Бууралт (-)
Хангамжийн материал	127.6	139.3	11.7
Бичиг хэргийн материал	0.3	0.3	0.1
Аж ахуйн материал	0.1	0.3	0.2
Сэлбэг хэрэгсэл	8.2	11.7	3.6
Түлш, шатах тослох материал	8.8	10.9	2.0
Бусад хангамжийн материал	110.2	116.1	5.9
Мал амьтад	8.2	18.0	9.8
Дүн	135.8	157.2	21.5

Эх сурвалж: Чандмань-Өндөр сумын ТТЗ-ийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Бараа материалын дансны үлдэгдэл 21.5 сая төгрөгөөр өсөхөд тайлант онд ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжсэн төсөл, арга хэмжээний үр дүнд бий болсон 10.0 сая төгрөгийн мал амьтдыг ЗДТГ-д бүртгэсэн нь голлох нөлөөг үзүүлсэн байна.

Аудитын илрүүлэлт

Бараа материал данстай холбоотой зөрчилтэй зүйл илрээгүй болно.

3.4.5 Урт хугацаат хөрөнгө оруулалт

Урт хугацаат хөрөнгө оруулалт дансны эцсийн үлдэгдэл 107.3 сая төгрөг болж, өмнөх оноос 39.6 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 5. Урт хугацаат зээлийн үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөгөөр/
			Өсөлт (+), Бууралт (-)
Хувь хүмүүст олгосон зээл	146.9	107.3	(39.6)
Дүн	146.9	107.3	(39.6)

Эх сурвалж: Чандмань-Өндөр сумын ТТЗ-ийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Урт хугацаат хөрөнгө оруулалт дансны үлдэгдэл 39.6 сая төгрөгөөр буурсан нь хоршоо хөгжүүлэх сангийн авлагыг хугацаагаар нь ангилан бүртгэсэнтэй холбоотой буурсан байна.

Аудитын илрүүлэлт

Урт хугацаат хөрөнгө оруулалт данстай холбоотой алдаа зөрчилтэй асуудал илрээгүй.

3.4.6 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл цэвэр дүнгээр 963.6 сая төгрөг болж, өмнөх оноос 5.4

сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 6. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөгөөр/ Өсөлт (+), Бууралт (-)
Биет хөрөнгө	883.6	878.2	(5.3)
Барилга, байгууламж, орон сууц	504.5	504.5	-
Хуримтлагдсан элэгдэл	(136.8)	(162.2)	(25.3)
Авто-тээврийн хэрэгсэл	154.2	229.2	75.0
Хуримтлагдсан элэгдэл	(53.2)	(75.4)	(22.2)
Машин тоног төхөөрөмж(компьютер)	334.3	373.6	39.3
Хуримтлагдсан элэгдэл	(99.9)	(147.0)	(47.2)
Тавилга, аж ахуйн эд хогшил	48.1	49.0	0.9
Хуримтлагдсан элэгдэл	(16.4)	(20.9)	(4.6)
Зам, гүүрний байгууламж	49.0	49.0	-
Хуримтлагдсан элэгдэл	(9.8)	(14.3)	(4.6)
Бусад үндсэн хөрөнгө	197.5	197.5	-
Хуримтлагдсан элэгдэл	(88.2)	(104.8)	(16.7)
Биет бус хөрөнгө	85.5	85.4	(0.1)
Программ хангамж	3.3	3.1	(0.2)
Хуримтлагдсан элэгдэл	(1.8)	(1.7)	0.0
Бусад биет бус хөрөнгө	84.0	84.0	-
Дүн	969.1	963.6	(5.4)

Эх сурвалж: Чандмань-Өндөр сумын ТТЗ-ийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Үндсэн хөрөнгө данс 5.4 сая төгрөгөөр буурсан нь тайлант онд харьяа байгууллагууд 42.3 сая төгрөгийн хөрөнгийг худалдан авсан, 88.6 сая төгрөгийн хөрөнгийг шилжүүлэн авсан, 15.8 сая төгрөгийн хөрөнгийг акталж, 133.7 сая төгрөгийн элэгдлийн зардал байгуулсантай холбоотой байна.

Аудитын илрүүлэлт:

Аудитаар үндсэн хөрөнгийн данс бүртгэлтэй холбоотой алдаа зөрчилтэй асуудал илрээгүй.

3.4.7 Өр төлбөр

Өр төлбөр дансанд бүртгэлтэй байсан 0.1 сая төгрөгийн өглөгийг тайланд онд барагдуулсан байна.

Хүснэгт 7. Өр төлбөр

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөгөөр/ Өсөлт (+), Бууралт (-)
Ажиллагчидтай холбоотой өглөг	0.1	0.0	(0.1)
Дүн	0.1	0.0	(0.1)

Эх сурвалж: Чандмань-Өндөр сумын ТТЗ-ийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Аудитын илрүүлэлт

Өр төлбөр данстай холбоотой зөрчилтэй зүйл илрээгүй болно.

3.4.8 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эцсийн үлдэгдэл 1,878.2 сая төгрөг болж, өмнөх оноос 361.4 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

Хүснэгт 7. Засгийн газрын хувь оролцоо

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөгөөр/ Өсөлт (+), Бууралт (-)
Засгийн газрын оруулсан капитал	330.2	330.2	-
Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө	330.2	330.2	-
Хуримтлагдсан үр дүн	878.0	1,239.4	361.4
Өмнөх үеийн үр дүн	1,218.7	877.5	(341.1)

Хөвсгөл аймгийн Чандмань-Өндөр сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайлан

Тайлант үеийн үр дүн	(340.7)	361.9	702.6
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	308.6	308.6	-
Дүн	1,516.8	1,878.2	361.4

Эх сурвалж: Чандмань-Өндөр сумын ТТЗ-ийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 361.4 сая төгрөгөөр нэмэгдсэн нь тайлант оны үр дүнтэй холбоотой байна.

Аудитын илрүүлэлт:

Засгийн газрын хувь оролцоо данстай холбоотой зөрчилтэй асуудал илрээгүй болно.

3.4.9. Орлогын данс

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангаар нийт 1,961.1 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж тайлагнасан байна.

Хүснэгт №2 Санхүүгийн үр дүнгийн нийт орлого /сая төгрөг/

Үзүүлэлт	Тайлант он	Устгал	Цэвэр дүн
Татварын орлого	800.5	800.5	800.5
Татварын бус орлого	112.2	80.0	32.2
Тусламж санхүүжилтийн орлого	2,744.8	1,616.5	1,128.3
Нийт дүн	3,657.6	11,696.5	1,961.1

Эх сурвалж: Чандмань-Өндөр сумын ТТЗ-ийн 2024 оны санхүүгийн үр дүнгийн тайлан

Санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайланд харьяа байгууллагуудын 1,696.5 сая төгрөгийн 18 орлогын давхардсан гүйлгээ, мөнгөн гүйлгээний тайланд 1,616.5 сая төгрөгийн 14 орлогын давхардсан гүйлгээг устгаж цэвэр дүнгээр тайлагнасан байна.

3.4.10. Зардлын данс

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн үр дүнгийн тайлангаар 1,599.2 сая төгрөгийн зардал тайлагнасан байна.

Хүснэгт №3: Санхүүгийн үр дүнгийн нийт зардал

Үзүүлэлт	Тайлант он	Устгал	Цэвэр дүн
Бараа, ажил үйлчилгээний зардал	1,463.5		1,463.5
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	711.1		711.1
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	88.5		88.5
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	235.8		235.8
Хангамж, бараа материалын зардал	150.1	80.0	70.1
Эд хогшил, урсгал засварын зардал	147.6		147.6
Томилолт, зочны зардал	6.5		6.5
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	31.0		31.0
Бараа үйлчилгээний бусад зардал	173.0		173.0
Бусад урсгал шилжүүлэг	1,713.6	1,616.5	97.1
Үйл ажиллагааны зардлын дүн	3,257.2		1,560.6
Үйл ажиллагааны бус зардлын дүн	38.6		38.6
НИЙТ	3,295.8	1,696.5	1,599.2

Эх сурвалж: Чандмань-Өндөр сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2024 оны санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант онд харьяа байгууллагууд 1,560.6 сая төгрөгийн үйл ажиллагааны зардал, 38.6 сая төгрөгийн үйл ажиллагааны бус зардлын дүн тайлагнасан байна.

Санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайланд харьяа байгууллагуудын 1,696.5 сая төгрөгийн зарлагын давхардсан 18 гүйлгээ, мөнгөн гүйлгээний тайланд 1,616.5 сая төгрөгийн зарлагын давхардсан 14 гүйлгээг устгаж цэвэр дүнгээр тайлагнасан байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Чандмань-Өндөр сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2024 оны орлогыг 326.3 сая төгрөгөөр төсөвлөж, харьяа байгууллагуудын зардлын төсвийн төслийг 1,085.3 сая төгрөгөөр нэгтгэж аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү төрийн сангийн хэлтэст хүргүүлж ажилласан байна.

Чандмань-Өндөр сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2023 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 06 дугаар тогтоолоор сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 8 хөтөлбөрт зориулан 1,809.3 сая төгрөгийн төсөв баталсан байна.

Нийт зардлын 872.5 сая төгрөгийг санхүүгийн дэмжлэгээс, 257.1 сая төгрөгийг орон нутгийн хөгжлийн сангаас, 495.0 сая төгрөгийг сумын орон нутгийн орлогоос, туслах үйл ажиллагааны орлогоос 4.0 сая төгрөгийг, хоршоо хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлтөөс 65.8 сая төгрөгийг, давсан орлого дансны үлдэгдлээс 114.9 сая төгрөгийг тус тус санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Тайлант онд Чандмань-Өндөр сумын ИТХ-ын 2024 оны 09 дүгээр сарын 25-ны өдрийн 01 дүгээр тогтоолоор төсөвт 64.7 сая төгрөгийн нэмэх тодотгол хийж төсвийг 1,846.1 сая төгрөгөөр баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Сумын төсвийн орлого бүрдүүлэлт.

Чандмань-Өндөр сумын ИТХ-ын “ Сумын 2024 оны төсөвт тодотгол оруулж батлах тухай” 2024 оны 9 дүгээр сарын 25-ны өдрийн 01 дүгээр тогтоолд зааснаар Чандмань-Өндөр сумын төсвийн төвлөрүүлэн захирагч нь тайлант онд 559.7 сая төгрөгийн орлогыг орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр баталсан байна. Гүйцэтгэлээр 804.9 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөө 143.8 хувийн биелэлттэй байна.

Хүснэгт №4. Төвлөрүүлэх орлого

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	/сая төгрөг/	
			Зөрүү	Хувь
Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрх	235.0	338.7	103.7	144.1
Үйл ажиллагааны орлого	5.0	7.1	2.1	141.6
Хөрөнгийн орлого	17.5	20.4	2.9	116.4
Хөрөнгө борлуулсны орлого	0.6	1.9	1.3	339.7
Шууд бус орлого	69.2	93.7	24.5	135.4
Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар	5.0	4.4	(0.6)	87.7
Бууны албан татвар	3.0	3.2	0.2	108.1
Малд ногдуулах албан татвар	25.0	25.1	0.1	100.2
Улсын тэмдэгтийн хураамж	6.0	4.7	(1.3)	78.7
Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	0.5	0.7	0.2	136.8
Хог хаягдлын үйлчилгээний хураамж	5.2	5.1	(0.1)	98.0
Газрын төлбөр	12.5	14.4	1.9	115.4
Дуудлага худалдаа	1.4	-	(1.4)	-
Ойн нөөц ашигласны төлбөр	162.8	278.0	115.2	170.7
Ан амьтны нөөц ашигласны төлбөр	3.9	0.4	(3.5)	9.6
Ус, рашааны нөөц ашигласны төлбөр	0.8	0.6	(0.2)	69.9
Байгалийн ургамлын нөөц ашигласны төлбөр	2.3	2.2	(0.1)	97.4
Торгуулийн орлого	4.0	4.3	0.3	108.2
НИЙТ ОРЛОГО	559.7	804.9	245.1	143.8

Эх сурвалж: Чандмань-Өндөр сумын ТТЗ-ийн 2024 оны төсвийн гүйцэтгэлийн танилцуулга

Чандмань-Өндөр сумын орон нутгийн орлого 245.1 сая төгрөгөөр давж биелэхэд тайлант онд цалин хөлс нэмэгдсэнтэй холбоотойгоор иргэдийн цалин хөлс өссөнөөс цалин хөлс, хөдөлмөр эрхлэлтийн орлого 103.7 сая төгрөгөөр, шууд бус орлого 24.5 сая төгрөгөөр, ойн нөөц ашигласны төлбөр 115.2 сая тус тус давж биелсэн нь голлох нөлөөг үзүүлсэн байна.

Аудитын илрүүлэлт:

Орон нутгийн орлогыг нэр төрлөөр нь авч үзвэл үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар 0.6 сая төгрөгөөр, улсын тэмдэгтийн хураамж 1.3 сая төгрөгөөр, хог хаягдлын үйлчилгээний хураамж 0.1 сая төгрөгөөр, дуудлага худалдааны орлого 1.4 сая төгрөгөөр, ан амьтны нөөц ашигласны төлбөр 3.5 сая төгрөгөөр, ус, рашааны нөөц ашигласны төлбөр 0.2 сая төгрөгөөр, байгалийн ургамлын нөөц ашигласны төлбөр 0.1 сая төгрөгөөр нийт 7.2 сая төгрөгөөр тасарсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1. “хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Зөвлөмж өгөх

Аймгийн төсөвт төвлөрүүлэх орлогын талаар: Тайлант онд аймагт төвлөрүүлэх орлогыг 14.1 сая төгрөгөөр төлөвлөж 22.2 сая төгрөгөөр гүйцэтгэлийг хангуулж 8.1 сая төгрөг буюу 57.4 хувиар давуулан биелүүлсэн байна.

Хүснэгт №5: Аймгийн төсөвт төвлөрүүлэх орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл

№	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	/сая төгрөг/ Зөрүү
1	АТБӨЯХ	10.0	17.2	7.2
2	Зам ашигласны төлбөр	3.5	5.0	1.5
3	Газрын дуудлага худалдаа	0.6		(0.6)
Нийт дүн		14.1	22.2	8.1

Эх сурвалж: Чандмань-Өндөр сумын ТТЗ-ийн 2024 оны төсвийн гүйцэтгэлийн танилцуулга

Аймгийн төсөвт төвлөрүүлэх орлогыг нэр төрлөөр нь авч үзвэл газрын дуудлага худалдааны орлого 0.6 сая төгрөгөөр тасарсан байна. Энэ нь тайлант онд дуудлага худалдаанд оролцогч ороогүйтэй холбоотой байна.

Улсын төсөвт төвлөрүүлэх орлогын талаар: Тайлант онд улсын төсөвт төвлөрүүлэх орлогыг 9.0 сая төгрөгөөр төлөвлөж 14.6 сая төгрөгөөр гүйцэтгэлийг хангуулж, 5.6 сая төгрөгөөр буюу 62.2 хувиар давуулан биелүүлсэн байна.

Хүснэгт №6: Улсын төсөвт төвлөрүүлэх орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл

№	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	/сая төгрөг/ Зөрүү
1	ААНОАТ	7.1	4.6	(2.4)
2	НӨАТатвар	0.9	7.8	6.9
3	Агаарын бохирдол /авто/	1.0	2.2	1.1
Нийт дүн		9.0	14.6	5.6

Эх сурвалж: Чандмань-Өндөр сумын ТТЗ-ийн 2024 оны төсвийн гүйцэтгэлийн танилцуулга

Улсын төсөвт төвлөрүүлэх орлогыг нэр төрлөөр нь бүрэн биелүүлсэн байна.

Төсвийн зарлагын талаар:

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 8 хөтөлбөрт зориулан 1,846.1 сая төгрөгийн төсөв батлагдсанаас 1,433.8 сая төгрөгийг урсгал зардалд, 347.4 сая төгрөгийг хөрөнгийн зардалд, 64.9 сая төгрөгийг эргэж төлөгдөх төлбөрийг хаасан цэвэр зээлийн зардалд зарцуулахаар батлагджээ.

Гүйцэтгэлээр урсгал зардалд 1,271.6 сая төгрөгийг, хөрөнгийн зардалд 225.6 сая төгрөгийг зарцуулсан байна. Хоршоо хөгжүүлэх сангаас зээл олгоогүй байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,497.2 сая төгрөг буюу 81.1 хувьтай байна.

Хүснэгт №6 Төсвийн гүйцэтгэлийн тайлан

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан	Зөрүү	Хувь
УРСГАЛ ЗАРДАЛ	1,433.8	1,271.6	162.2	88.7
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,389.9	1,228.1	161.8	88.4
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	805.2	711.2	94.0	88.3
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	100.6	88.4	12.3	87.8
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	231.9	227.8	4.1	98.2
Хангамж, бараа материалын зардал	40.0	37.2	2.9	92.8
Нормативт зардал	1.5	1.5	-	100.0
Эд хогшил, урсгал засварын зардал	61.6	60.6	1.1	98.3
Томилолт, зочны зардал	6.5	6.5	0.0	99.5
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	107.4	60.5	46.9	56.4

Бараа үйлчилгээний бусад зардал	35.1	34.5	0.6	98.3
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	43.9	43.6	0.4	99.2
Бусад урсгал шилжүүлэг	43.9	43.6	0.4	99.2
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	347.4	225.6	121.9	64.9
ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	64.9	-	64.9	-
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,846.1	1,497.2	348.9	81.1

Батлагдсан төсвөөс 348.9 сая төгрөгийг зарцуулаагүй нь хоршоо хөгжүүлэх сангаас олгохоор төлөвлөсөн 64.9 сая төгрөгийн зээлийг олгоогүй, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр батлагдсан 10 төсөл арга хэмжээ тайлант онд хэрэгжээгүйгээс 121.9 сая төгрөгийг зарцуулаагүй, харьяа байгууллагууд орон тоо дутуу ажилласнаас 94.0 сая төгрөгийг хэмнэсэн, байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардлаас 46.9 сая төгрөгийг зарцуулаагүйтэй тус тус холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн харьяа байгууллагууд нь дээд шатны төсөв захирагчаас 63.1 сая төгрөг, төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд олсон орлогоос 0.4 сая төгрөг нийт 63.5 сая төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Гүйцэтгэлээр бараа ажил үйлчилгээний зардалд 63.5 сая төгрөгийг зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

2024 онд гадаад, дотоодын эх үүсвэрээр ямар нэгэн төсөл хөтөлбөр хэрэгжээгүй байна.

3.5.5 Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, гүйцэтгэл

Чандмань-Өндөр сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг 2023 оны 12 дугаар сарын 23-ны өдөр баталж, цахим хуудсанд мэдээлсэн байна.

Чандмань-Өндөр сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч нь Төсвийн тухай хуулийн 54.5.3-д заасны дагуу харьяа байгууллагуудын худалдан авах ажиллагааны тайланг нэгтгэж тайлагнасан байна. Тайланд онд 90.0 сая төгрөгийн 1 бараа ажил үйлчилгээг нээлттэй тендер шалгаруулалтын аргаар, 170.9 сая төгрөгийн 6 бараа, ажил үйлчилгээг харьцуулалтын аргаар, 394.1 сая төгрөгийн 54 бараа, ажил үйлчилгээг шууд худалдан авалтын аргаар худалдан авах ажиллагааг тус тус зохион байгуулж ажилласан байна.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн харьяа байгууллагуудын худалдан авах ажиллагааны төлөвлөгөө гүйцэтгэлд сумын дотоод хяналтын нэгж хяналт хэрэгжүүлж ажилласан байна.

3.6 Санхүүгийн тайлангийн аудитын ерөнхий чиглэлийн хүрээнд авсан судалгааны үр дүн

Санхүүгийн тайлангийн аудитын ерөнхий чиглэлийн хүрээнд төсвийн шууд захирагчдаас дараах судалгаануудыг авч нэгтгэсэн байна. Үүнд:

1. Ахмадын сангийн судалгаа
2. Худалдан авах ажиллагааны судалгаа
3. Төсвөөс 2024 онд зарцуулсан бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр, хураамж /210801/-ийн судалгаа
4. Төсвөөс 2024 онд зарцуулсан бараа үйлчилгээний бусад зардал /210901/-ын судалгаа
5. Орон тооны судалгаа

Судалгааны хүрээнд илэрсэн зөрчлийг төсвийн шууд захирагчийн санхүүгийн тайлангийн аудитаар шийдвэрлэсэн болно.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Чандмань-Өндөр сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн орлогын биелэлт болон хоршоо хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлт, шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Г.Ичинхорлоо гүйцэтгэж, хяналтыг ахлах аудитор Б.Давааням аудитын менежер Б.Тэгшдэлгэр, дарга тэргүүлэх аудитор А.Эрдэнэбаатар нар хэрэгжүүлсэн.

Чандмань-Өндөр сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төрийн аудитын газарт 2025 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн 01/51 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр өмнөх оны үр дүнгийн тайлангийн нийт зардлын дүн 1,604.0 сая төгрөгийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2.0 хувиар тогтоож сонгосон суурь үзүүлэлтээс тооцож 32.1 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 25.7 сая төгрөгөөр тогтоосныг гүйцэтгэлийн шатанд дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн харьяа байгууллагуудын санхүүгийн үйл ажиллагаанд Төрийн хэмнэлтийн тухай хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой нийт 32 асуудлаар горим сорилыг хэрэгжүүлэхэд зөрчилтэй зүйл илрээгүй болно.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим хуудсанд мэдээлбэл зохих 226 мэдээллээс 189 мэдээллийг ил тод хугацаанд нь мэдээлж, 34 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлж, 3 мэдээллийг ил тод мэдээлэх хугацаа болоогүйн байна. Дараах мэдээллүүдийг хугацаа хоцроож мэдээлсэн байна. Үүнд:

- Аудитын тайлан, дүгнэлт зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан
- Орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөгөө гүйцэтгэл
- ТТЗ-ийн төсвийн хөтөлбөр, зориулалтын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт
- Улсын төсөв болон орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл
- Төсвийн төвлөрүүлэн захирагчийн төсвийн хөтөлбөр, зориулалтын батлагдсан төсөв, гүйцэтгэл гэсэн мэдээллүүдийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

- Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын мөнгөн гүйлгээ
- Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын мөнгөн гүйлгээ

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4.1.3.тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх гэсэн заалттай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Аудитын шийдвэрлэлт:

Зөвлөмж өгөх

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Чандмань-Өндөр сумын санхүү албаны дарга нь төрийн сангийн мэргэжилтний ажлыг хавсран гүйцэтгэж байгаа нь Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1. “Албан тушаалтан албан үүргээ гүйцэтгэхдээ өөрийн болон өөртэй нь хамаарал бүхий этгээдийн хувийн ашиг сонирхлыг хөндсөн захиргааны шийдвэр гаргах, удирдах, хяналт, шалгалт хийх, хариуцлага хүлээлгэх, гэрээ байгуулах, эдгээрийг хэлэлцэх, бэлтгэх, оролцох зэрэг үйл ажиллагаа явуулахыг хориглоно” гэж заасантай нийцэхгүй, “нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Аудитын шийдвэрлэлт:

Зөвлөмж өгөх

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Чандмань-Өндөр сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд завсрын аудит хийгээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 2 зөвлөмжийн хэрэгжилтийг хянаж үзэхэд тайлант онд бүрэн хэрэгжүүлж ажилласан байна.

Хүснэгт 7 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	2	131.0	2	131.0	100
Нийт дүн	2	131.0	2	131.0	100

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарч үзэх асуудал байхгүй байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд сумын орон нутгийн ерөнхий орлого болон харьяа 2 төсвийн байгууллага, 2 тусгай сан, нийт 5 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 1 байгууллагад дүгнэлт гаргаж, 4 байгууллага түүвэрт хамрагдсан байна.

№	Байгууллагын нэр	Аудитын дүгнэлт
1	Засаг даргын Тамгын газар	Өөрчлөлтгүй дүгнэлт
2	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал	Түүвэрт хамрагдсан
3	Хоршоо хөгжүүлэх сан	Түүвэрт хамрагдсан
4	Орон нутгийн хөгжлийн сан	Түүвэрт хамрагдсан

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар 3 зөвлөмжийг өгсөн байна.

Аудитаар төсөвт төвлөрүүлэх орлогын бүрдэлт болон хоршоо хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлт, шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт, төрийн сангийн мэргэжилтний ажлын байртай холбоотой 28.5 сая төгрөгийн зөрчил илэрч 4 зөвлөмжийг хүргүүлж байна.

5.1 Төлбөрийн акт

Төлбөрийн акт тогтоогоогүй болно.

5.2 Албан шаардлага

Албан шаардлага, хариуцлага тооцох санал хүргүүлээгүй болно.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Орлого бүрдүүлэлттэй холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Орон нутгийн орлогыг нэр төрлөөр нь авч үзвэл үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар 0.6 сая төгрөгөөр, улсын тэмдэгийн хураамж 1.3 сая төгрөгөөр, хог хаягдлын үйлчилгээний хураамж 0.1 сая төгрөгөөр, дуудлага худалдааны орлого 1.4 сая төгрөгөөр, ан амьтны нөөц ашигласны төлбөр 3.5 сая төгрөгөөр, ус, рашааны нөөц ашигласны төлбөр 0.2 сая төгрөгөөр, байгалийн ургамлын нөөц ашигласны төлбөр 0.1 сая төгрөгөөр нийт 7.2 сая төгрөгөөр тасарсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1. "хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх" гэсэн заалттай нийцэхгүй, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

1.2. Өгсөн зөвлөмж:

Улс, орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлогыг бодитой төлөвлөж, гүйцэтгэлийг нэр төрлөөр нь жигд ханган биелүүлж ажиллах.

2. Хоршоо хөгжүүлэх сангийн хугацаа хэтэрсэн зээлтэй холбоотой асуудал

2.1. Илрүүлэлт:

Хоршоо хөгжүүлэх сангийн хугацаа хэтэрсэн зээлийн 8 иргэнтэй холбоотой 21.2 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна. Энэ нь Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2021 оны 361 дүгээр тушаалаар баталсан "хоршоог хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журам"-ын 3.2.1."орон нутгийн жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх тэргүүлэх чиглэлийг жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ, хоршоо хөгжүүлэх бодлоготой уялдуулан тогтоож, хэрэгжилтийг зохион байгуулах, биелэлтэд нь хяналт тавих" гэсэн заалттай нийцэхгүй, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

2.2. Өгсөн зөвлөмж:

Хоршоо хөгжүүлэх сангийн хугацаа хэтэрсэн зээлийн авлагыг барагдуулж ажиллах.

3. Дотоод хяналт хариуцлагатай холбоотой

3.1. Илрүүлэлт:

Чандмань-Өндөр сумын санхүү албаны дарга нь төрийн сангийн мэргэжилтний ажлыг хавсран гүйцэтгэж байгаа нь Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1. "Албан тушаалтан албан үүргээ гүйцэтгэхдээ өөрийн болон өөртэй нь хамаарал бүхий этгээдийн хувийн ашиг сонирхлыг хөндсөн захиргааны шийдвэр гаргах, удирдах, хяналт, шалгалт хийх, хариуцлага хүлээлгэх, гэрээ байгуулах, эдгээрийг хэлэлцэх, бэлтгэх, оролцох зэрэг үйл ажиллагаа явуулахыг хориглоно" гэж заасантай нийцэхгүй, "нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна

3.2. Өгсөн зөвлөмж:

Төрийн сангийн мэргэжилтний ажлын байранд ашиг сонирхлын зөрчилтэй албан тушаалтныг хавсран ажиллуулахгүй байх

4. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой

4.1. Илрүүлэлт:

Шилэн дансны цахим хуудсанд нийт 34 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4.1.3.тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх гэсэн заалттай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

4.2. Өгсөн зөвлөмж:

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж, мэдээллийг хугацаанд нь ил тод мэдээлж ажиллах

Дээрх зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг аудитын тайлан хүлээн авсан өдрөөс хойш 30 хоногийн дотор, зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагын Fas.audit.mn цахим системд 2025 оны 09 дүгээр сарын 20 -ны өдрийн дотор мэдээлж, баталгаажуулна уу

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Чандмань-Өндөр ТТЗ	2	28.5					2	28.5				
Дүн	2	28.5					2	28.5	0	0	0	0
Харьяа байгууллагуудын зөрчил												
Чандмань-Өндөр сумын ЗДТГ												
Чандмань-Өндөр сумын ИТХ												
Дүн	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
Нийт дүн	2	28.5					2	28.5				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/сая төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс						
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил									
Чандмань-Өндөр ТТЗ	2	-						2	
Харьяа байгууллагуудын зөрчил									
Чандмань-Өндөр ЗДТГ	3	0.0						3	0.0
Дүн	3	0.0						3	0.0
Нийт дүн	5	0.0	0	0	0	0	5	0.0	

АУДИТЫН ТАЙЛАНГ:

ХОЁР ДАХЬ ШАТАНД ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АНХАН ШАТАНД ХЯНАСАН:

АУДИТЫН МЕНЕЖЕР

АХЛАХ АУДИТОР

БАТАЛГААЖУУЛСАН

АХЛАХ АУДИТОР



А.ЭРДЭНЭБААТАР ОГНОО:

Б.ТЭГШДЭЛГЭР ОГНОО:

Б.ДАВААНЫМ ОГНОО:

Г.ИЧИНХОРЛОО ОГНОО:

Ilukhon

Uky